

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/189/НА-СТА-ТШЗ

Чингис хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Н.Хэрлэнбаяр Утас: 89051308 Цахим хаяг: kherlenbayarn@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25 № 432
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА С.ХЭРЛЭНЧИМЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 549,680.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагааны зардалд 448,278.2 мянган төгрөгийг зарцуулан, орон нутгийн төсөвт 101,402.7 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ гараагүй байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар 4,569.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,891.9 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 1,046.5 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 631.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлжээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, 99.0 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	15,268,822.70	12,382,376.30
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,800.00	677,294.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,800.00	677,294.00
3121	Төгрөг	1,800.00	677,294.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	1,800.00	677,294.00
33	АВЛАГА	3,913,184.70	505,984.30
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,913,184.70	505,984.30
35	БАРАА МАТЕРИАЛ	11,353,838.00	11,199,098.00
354	Хангамжийн материал	11,353,838.00	11,199,098.00
35410	Бичиг хэргийн материал	960,600.00	894,700.00
35420	Аж ахуйн материал	10,393,238.00	10,204,398.00
35440	Түлш, шатах тослох материал	-	100,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	58,430,679.26	50,220,616.87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	58,430,679.26	50,220,616.87
392	Биет хөрөнгө	58,430,679.26	50,220,616.87
39203	Авто-тээврийн хэрэгсэл	44,900,000.00	44,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(18,737,083.77)	(26,220,417.09)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,897,300.00	44,846,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(15,630,999.87)	(22,426,663.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,531,400.00	25,306,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,529,937.10)	(16,185,602.80)
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(450,000.00)	(450,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	73,699,501.96	62,602,993.17
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,913,184.70	5,004,800.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,913,184.70	5,004,800.00
413	Өглөг	3,913,184.70	5,004,800.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,913,184.70	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	3,864,000.00
4136	Бусад өглөг	-	1,140,800.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,140,800.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	69,786,317.26	57,598,193.17
51	Засгийн газрын хувь оролцоо	69,786,317.26	57,598,193.17
512	Хуримтлагдсан үр дүн	69,786,317.26	57,598,193.17
51210	Өмнөх үеийн үр дүн	69,786,317.26	69,786,317.26
51220	Тайлант үеийн үр дүн	-	(12,188,124.09)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	73,699,501.96	62,602,993.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	565,633,294.00	553,680,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,528,194.00	4,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	32,528,194.00	4,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32,528,194.00	4,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	32,528,194.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	533,105,100.00	549,680,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	533,105,100.00	549,680,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	533,105,100.00	549,680,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	533,225,016.97	565,869,024.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	533,225,016.97	565,869,024.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	379,316,432.97	464,066,307.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	260,725,043.00	340,859,527.47
210101	Үндсэн цалин	133,808,634.00	174,521,316.70
210102	Нэмэгдэл	96,601,202.00	117,973,934.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,240,000.00	25,617,741.00
210104	Урамшуулал	9,075,207.00	22,746,535.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,590,636.00	42,522,221.57
210201	Тэтгэврийн даатгал	22,161,628.00	28,915,108.46
210202	Тэтгэмжийн даатгал	2,357,116.00	3,401,780.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,928,955.00	1,700,887.80
210204	Ажилгүйдлийн даатгал	928,433.00	1,719,864.80
210205	Эрүүл мэндийн даатгал	5,214,504.00	6,784,580.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,417,600.00	9,417,600.00
210304	Байрны түрээс	9,417,600.00	9,417,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,824,388.60	16,860,921.00
210401	Бичиг хэрэг	2,530,000.00	1,773,600.00
210402	Тээвэр, шатахуун	6,175,015.60	5,882,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,469,930.00	2,938,875.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,649,443.00	6,266,446.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,204,117.00	4,400,900.00
210604	Урсгал засвар	25,204,117.00	4,400,900.00
2107	Томилолт, зочны зардал	19,620,000.00	25,100,000.00
210702	Дотоод албан томилолт	19,620,000.00	25,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	450,000.00	1,446,969.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	675,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	164,969.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	87,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	29,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	490,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,484,648.37	23,458,168.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,250,000.00	7,324,506.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	199,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,234,648.37	15,934,662.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153,908,584.00	101,802,716.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,361,847.00	400,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	39,131,847.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,230,000.00	400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	113,546,737.00	101,402,716.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	113,546,737.00	101,402,716.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	32,408,277.03	(12,188,124.09)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	32,408,277.03	(12,188,124.09)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	533,105,100.00	553,680,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	4,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	4,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	4,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	533,105,100.00	549,680,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	533,105,100.00	549,680,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	533,105,100.00	549,680,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	533,105,100.00	545,280,806.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	533,105,100.00	545,280,806.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	379,846,516.00	443,478,089.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	260,725,043.00	341,365,511.77
210101	Үндсэн цалин	123,267,187.00	175,027,301.00
210102	Нэмэгдэл	107,142,649.00	117,973,934.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,240,000.00	25,617,741.00
210104	Урамшуулал	9,075,207.00	22,746,535.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,590,636.00	42,522,221.57
210201	Тэтгэврийн даатгал	22,161,627.00	28,915,108.46
210202	Тэтгэмжийн даатгал	2,424,963.00	3,401,780.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,662,723.00	1,700,887.80
210204	Ажил үйлдлийн даатгал	1,126,819.00	1,719,864.80
210205	Эрүүл мэндийн даатгал	5,214,504.00	6,784,580.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,417,600.00	9,417,600.00
210304	Байрны түрээс	9,417,600.00	9,417,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,967,837.00	11,490,375.00
210401	Бичиг хэрэг	2,948,440.00	1,110,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,765,000.00	5,982,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,469,930.00	2,968,875.00
210404	Ном, хэвлэл	-	84,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,784,467.00	1,345,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,965,400.00	7,537,147.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,500,000.00	435,000.00
210602	Тавилга	6,110,000.00	-
210604	Урсгал засвар	21,355,400.00	7,102,147.00
2107	Томилголт, зочны зардал	19,620,000.00	21,236,000.00
210702	Дотоод албан томилголт	19,620,000.00	21,236,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	450,000.00	1,446,969.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	675,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	164,969.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	87,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	29,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	490,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,110,000.00	8,462,265.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,630,000.00	7,324,506.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	480,000.00	1,137,759.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153,258,584.00	101,802,716.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,711,847.00	400,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	39,131,847.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	580,000.00	400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох тагаас, санхүүжилт	113,546,737.00	101,402,716.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	113,546,737.00	101,402,716.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	8,400,094.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	7,724,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	7,724,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	7,724,600.00
222001	Тоног төхөөрөмж	-	4,949,600.00
223001	Бусад хөрөнгө	-	2,775,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(7,724,600.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	675,494.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,800.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,800.00	677,294.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			37,378,040.23		37,378,040.23
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	37,378,040.23	-	37,378,040.23
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	32,408,277.03		32,408,277.03
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			69,786,317.26	-	69,786,317.26
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			69,786,317.26	-	69,786,317.26
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	69,786,317.26	-	69,786,317.26
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(12,188,124.09)		(12,188,124.09)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	57,598,193.17	-	57,598,193.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	549,680,900.00	448,278,183.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	549,680,900.00	448,278,183.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	544,680,900.00	447,878,183.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	405,491,400.00	341,365,511.77
210101	Үндсэн цалин	180,066,100.00	175,027,301.00
210102	Нэмэгдэл	154,440,400.00	128,644,934.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,400,000.00	25,617,741.00
210104	Урамшуулал	31,584,900.00	12,075,535.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,686,400.00	42,522,221.57
210201	Тэтгэврийн даатгал	34,466,600.00	28,915,108.46
210202	Тэтгэмжийн даатгал	4,055,000.00	3,401,780.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,027,500.00	1,700,887.80
210204	Ажилгүйдлийн даатгал	2,027,500.00	1,719,864.80
210205	Эрүүл мэндийн даатгал	8,109,800.00	6,784,580.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,417,600.00	9,417,600.00
210304	Байрны түрээс	9,417,600.00	9,417,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,429,200.00	11,490,375.00
210401	Бичиг хэрэг	2,557,000.00	1,110,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,908,200.00	5,982,000.00
210403	Шуудан, холбоо, ингэрнэгийн төлбөр	3,196,000.00	2,968,875.00
210404	Ном, хэвлэл	168,000.00	84,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,600,000.00	1,345,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,450,000.00	15,261,747.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,900,000.00	5,384,600.00
210602	Тавилга	3,550,000.00	2,775,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	7,102,147.00
2107	Томилолт, зочны зардал	24,549,300.00	21,236,000.00
210702	Дотоод албан томилолт	24,549,300.00	21,236,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,607,000.00	1,446,969.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	-	675,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	450,000.00	164,969.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	87,300.00	87,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,700.00	29,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	490,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,050,000.00	5,137,759.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	4,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,050,000.00	1,137,759.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,000,000.00	400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,000,000.00	400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	400,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	549,680,900.00	448,278,183.34
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	549,680,900.00	448,278,183.34
132001	Орон нутгийн төсвөөс	549,680,900.00	448,278,183.34
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 2,891.9 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн тайланд тайлант үеийн элэгдлийн зардлыг 2,589.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг нэмэгдүүлж залруулав.
2. ХХОАТ-ын 302.0 мянган төгрөг авлага дутуу тайлагнасныг авлагыг нэмэгдүүлж залруулсан.

Аудитаар нийт 1,678.0 мянган төгрөгийн зөрчил илэрч, 1,046.5 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 631.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

1. Сангийн яам болон Баянгол дүүргийн Дотоод аудитын албанаас зохион байгуулсан үзүүлэх сургалтад удирдамжид заагдаагүй албан тушаал бүхий албан хаагч хамрагдаж 200.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг илүү олгосон нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалт, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Тайлант онд шилжин ирсэн ажилтанд тухайн байгууллагад томилогдон ажиллахаас өмнөх хугацаанд хамаарах 846.5 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал тооцон олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2.2-т “төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид.”, 2.1-т “Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно.” гэсэн заалт, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

1. Хичээл үйлдвэрлэлийн зардлаас “Гэр бүлийн баяр хөөр” сэдэвт өдөрлөг сургалт зохион байгуулж 631.5 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” гэсэн заалт, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

Байхгүй.

Төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор fas.audit.mn системд бүртгэн илгээж, аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлэх.

Аудитаар илрүүлсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс бага тул **“Өөрчлөлтгүй”** дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Элэгдэл дутуу тайлагнасан	1	2,589.9			1	2,589.9	1	2,589.9				
Авлага дутуу бүртгэсэн	1	302.0			1	302.0	1	302.0				
Дүн	1	2,891.9	0	0.00	1	2,891.9	1	2,891.9	0	0.00	0	0.00

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Урамшуулал илүү олгосон	1	846.5	1	846.5								
Томилолт илүү олгосон	1	200.0	1	200.0								
Зориулалт бус зарцуулсан	1	631.5			1	631.5						
Дүн	3	1,678.0	2	1,046.5	1	631.5						

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			


**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 56-А2371281

Чингис хот

ХЭА-2026/189/ХА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Сангийн яам болон Баянгол дүүргийн ДАА-аас зохион байгуулсан үзүүлэх сургалтад удирдамжид заагдаагүй албан тушаал бүхий албан хаагч хамрагдаж 200,000.00 (хоёр зуун мянга) төгрөгийн томилолтын зардлыг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн.” гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Илүү олгосон 200,000.0 (хоёр зуун мянга) төгрөгийг дарга С.Хэрлэнчимэгээр төлүүлж аймгийн Төрийн сан банк дахь “Нэр заагдаагүй бусад орлого” 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг дарга С.Хэрлэнчимэгт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:


ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Н. Хэрлэнбаяр

Ж.ТАНБААТАР

Н.ХЭРЛЭНБАЯР





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 57-А/2371281

Чингис хот

ХЭА-2026/189/НА-СТА-ТШЗ

Г

Төлбөр барагдуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилжин ирсэн ажилтанд тухайн байгууллагад томилогдон ажиллахаас өмнөх хугацаанд хамаарах 846,500.00 (найман зуун дөчин зургаан мянга таван зуу) төгрөгийн үр дүнгийн урамшуулал тооцон олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2-т “Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно.”, 1.2.2-т “төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид.”, 2.1-т “Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно.”, 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-т “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон;” гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Үндэслэлгүй олгосон урамшуулал 846,500.00 (найман зуун дөчин зургаан мянга таван зуу) төгрөгийг дарга С.Хэрлэнчимэгээр төлүүлж, аймгийн Төрийн сан банк дахь “Нэр заагдаагүй бусад орлого” 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.


2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг дарга С.Хэрлэнчимэгт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Н. Хэрлэн



Ж. ГАНБААТАР

Н. ХЭРЛЭНБАЯР



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24

Дугаар 102-А2371281

Чингис хот

ХЭА-2026/189/НА-СТА-ТШЗ

Г Зөрчил таслан зогсоох тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд хичээл үйлдвэрлэлийн зардлаас "Гэр бүлийн баяр хөөр" сэдэвт өдөрлөг сургалт зохион байгуулж 631,459.00 (зургаан зуун гучин нэгэн мянга дөрвөн зуун тавин ес) төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга С.Хэрлэнчимэгт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Н. Борзор



Ж. ГАНБААТАР

Н. ХЭРЛЭНБАЯР